

8.6.21 /15/ Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт


Аймгийн Засаг даргын санаачилгаар 2019 оноос эхлэн 21 аймагт анхдагч сумдад нэн шаардлагатай боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх зорилгоор сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх "Нутгийн ирээдүй" төслийг хэрэгжүүлсэн. Боловсролын салбарт дутагдалтай багш мэргэжлээр 2021-2024 онд суралцаж буй 24 оюутанд нийт 81,689,820 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. 2024 онд багш мэргэжлээр 6 төгссөнөөс гэрээний дагуу орон нутагтаа Б.Дэлгэржаргал Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуульд технологийн багшаар, Э.Батцэцэг Халхгол сумын ерөнхий боловсролын сургуульд хими биологийн багшаар тус тус ажиллаж байна.

2022 оны төгсөгч Х.Ариунчимэг энэ хичээлийн жилээс эхлэн Чойбалсан сумын Ерөнхий боловсролын сургуульд багшаар ажиллахаар боллоо.
"НУТГИЙН ИРЭЭДҮЙ" төслийн төгсөгч Танд ажлын амжилт хүсье!



2019 оны төгсөгч С.Нямдаваа Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн дуу хөгжмийн багшаар ажиллаж бна

"НУТГИЙН ИРЭЭДҮЙ" төслийн төгсөгч Танд ажлын амжилт хүсье!



2024 онд шинээр "Нутгийн ирээдүй" сургалтын төлбөрийн тэтгэлэгт нийт 15 оюутан шинээр хамрагдсанаас багш мэргэжлээр сумандаа ажиллах гэрээний дагуу 2024 онд нийт 4 оюутан шинээр тэтгэлэгт хамрагдаж, үргэлжлүүлэн 19 оюутан суралцаж байна.